

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022.01.27

Дархан-Уул

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасны дагуу Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн “Дархан-Уул аймгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

Гурав. Үнэлгээний дүгнэлт

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн **6 бүлэг, 21 дэд бүлэг, 64 зорилтын хүрээнд 286 арга хэмжээг** хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **95,87%** буюу **4.79** онооны үнэлгээтэй байна.

Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг үнэлгээний шатлалаар задалж харуулбал:

№	Хэрэгжилтийн үнэлгээ, хувь	Арга хэмжээний тоо, эзлэх хувь
1	Үр дүнтэй буюу 100.0 %	237 (82.87%)
2	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 90.0%	25 (8.7%)
3	Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	19 (6.6%)
4	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	1 (0.3%)
5	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	3 (1.05%)
6	Үр дүнгүй 0.0%	1 (0.3%)

График 1.




“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д 2021 онд хэрэгжүүлэхээр тусгасан 285 арга хэмжээнээс 281 арга хэмжээг **ХАНГАЛТТАЙ** гэж үнэлэв.

Хэрэгжүүлэхээр тусгасан 285 арга хэмжээг хариуцах хэлтэс, алба тус бүрээр задлан харуулбал:

1. Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс – 26 зорилт 122 арга хэмжээ /**94,34%**/
2. Нийгмийн бодлогын хэлтэс – 26 зорилтын 118 арга хэмжээ /**97,20%**/
3. Төрийн захиргаа удирдлагын хэлтэс – 4 зорилт 19 арга хэмжээ /**98.94%**/
4. Хууль эрх зүйн хэлтэс – 3 зорилт 11 арга хэмжээ /**96.36%**/
5. Санхүү төрийн сангийн хэлтэс – 2 зорилт 6 арга хэмжээ /**100%**/
6. Онцгой байдлын газар – 1 зорилт 4 арга хэмжээ /**97.5%**/
7. Цэргийн штаб - 1 зорилт 3 арга хэмжээ /**73,33%**/
8. Мэдээлэл технологийн алба – 1 зорилт 3 арга хэмжээ /**100%**/

График 2.



“Дархан-Уул Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг бодлого тус бүрээр харуулбал:

Хүснэгт 2

№	Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	Хүний хөгжлийн бодлого	25	110	97.00% буюу 4.85 оноо
2	Эдийн засгийн бодлого	17	88	95.11% буюу 4.76 оноо
3	Засаглалын бодлого	10	40	96.00% буюу 4.80 оноо
4	Ногоон хөгжлийн бодлого	8	27	95.19% буюу 4.76 оноо
5	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	3	12	89.17% буюу 4.46 оноо
6	Халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого	1	9	100.00% буюу 5.00 оноо
Ерөнхий, дундаж үнэлгээ				95.87% буюу 4.79 оноо

Дөрөв. Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ

Зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт болон тухайн жилд дэвшүүлсэн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу **50.0%, 30.0%, 0%-иар** үнэлэгдсэн дараах арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 3

№	Үнэлгээ	Тоо	Арга хэмжээний дугаар	Хариуцах хэлтэс
1	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50.0%	1	51	НБХ-1
2	Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30.0%	3	137, 256, 270	ХОХБТХ-2, ЦШ-1
3	Үр дүнгүй 0.0%	4	303	ХОХБТХ-1

Тав. Дүгнэлт

“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д 2021 онд хэрэгжүүлэхээр тусгасан 286 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн “Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг бодлогын холбогдох хэлтэс, агентлагуудад хэрэгжүүлэх 179 арга хэмжээний хэрэгжилтийг бүхэлд нь буцааж, 2021 оны 11 дүгээр сарын 8-22-ны өдрүүдэд бодлогын 5 хэлтэс, 7 агентлаг зэрэг төрийн байгууллагын 15 мэргэжилтнүүдтэй холбогдож тодруулга, нэмэлт мэдээлэл авч, эргэх холбоо үүсгэн ажиллаж, үг үсгийн алдаа, найруулга, тоон мэдээллийн засвар өөрчлөлтийг дахин хийсний үр дүнд 63 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дүн тодорхой хувиар нэмэгдсэн.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд нийт 286 арга хэмжээнээс зорилт, арга хэмжээний биелэлт, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүнтэй хэрэгжсэн 237 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 44 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээ, үр дүнгүй 1 арга хэмжээ дүгнэгдэж ерөнхий үнэлгээ **95,87%** буюу **4.79** оноогоор “**тодорхой үр дүнд хүрсэн**” гэж дүгнэлээ.

Зургаа. Цаашид анхаарах асуудал: / ЗӨВЛӨМЖ /

1. “Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг”-г боловсруулахдаа арга

- хэмжээний хүрэх түвшинг тооцоо, судалгааны үндсэн дээр тоо болон чанарын үзүүлэлтээр илэрхийлж болохуйц байдлаар, шалгуур үзүүлэлтийг бодитой, хэмжиж болохуйц байдлаар, оновчтой тодорхойлох,
2. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг бүр тухайн онд хийсэн ажлын үр дүнг 1000-2000 тэмдэгтэд багтаан бодит үр дүнг тоо баримтаар тайлагнахад онцгой анхаарч, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний багаар өөрийн үнэлгээг өгч, удирдах албан тушаалтантай танилцуулж, гарын үсгээр баталгаажуулан, хугацаанд нь аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтэстээ хүргүүлэхэд анхаарах,
 3. Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр үнэлэх,
 4. Аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд агентлагаас ирүүлсэн хэрэгжилтэд хийсэн ажлын үр дүнг бүрэн гүйцэт тусгасан эсэх, найруулга үг үсгийн алдааг хянах, “Эрчимжүүлэх шаардлагатай, удаашралтай” арга хэмжээний шалтгаан нөхцөл, сайжруулах гарц шийдлийн саналыг тусгаж байх,
 5. Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс боловсруулан аймгийн ЗДТГ-ын даргаар 2021.03.30-ны өдөр батлуулсан “Зөвлөмж” (үнэлгээний арга зүй, аргачлал)-ийг бүх албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах, тус хэлтэстэй эргэх холбоотой, харилцан суралцах чиглэлд санаачлагатай хамтарч ажиллах,
 6. Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хийгдсэн ажлууд орон нутгийн иргэдэд хэрхэн хүрч байгаа талаар мэдээлэл гаргаж, аймгийн иргэдэд сурталчлахыг,
 7. Төрийн захиргааны байгууллага бүр чиг үүргийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагаа болон иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх, үр дүнтэй тайлагнаж иргэдээс гарсан саналыг жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхийг,
 8. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээ тус бүрт

зарцуулсан хөрөнгийг түүний эх үүсвэрийн хамт бичихийг шаарддаг тул цаашид хэрэгжилтийг ирүүлэхдээ зарцуулсан хөрөнгийн эх үүсвэрийг дурдахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
МЭРГЭЖИЛТЭН Э.ХОНГОРЗУЛ

